



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/291

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар (Г.Ганхүү)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 7,327.1 (долоон тэрбум гурван зуун хорин долоон сая нэг зуун мянга) сая төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “24.1.15.”-ын “13”-т заасан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил (Улаанбаатар хот)”-ын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020001604

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 01-ны өдрийн
А/291 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕРИЙН
ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГА
УГСРАЛТЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн дэд бүтцийн гадна цахилгаан хангамж, холбооны шугам сүлжээ (БЗД, 13 дугаар хороо)	2022	2023	3,616.4	1,500.0
2	14 дүгээр хороолол, "И" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлтийн борооны ус зайлуулах шугам сүлжээ (БЗД, 13 дугаар хороо)	2022	2023	380.4	100.0
3	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Эко яармаг-1" хорооллын гадна дулаан хангамж (ХУД, 4 дүгээр хороо)	2022	2023	3,293.4	1,000.0
4	Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил	2022	2023	3,783.6	1,000.0
5	Бичил 7 дугаар хороолол орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Б" блокын гадна дулаан хангамжийн ажил (БГД, 11, 22 дугаар хороо)	2022	2023	3,278.0	1,000.0
6	"Туул дэд станц", "Дүнжингарав" дэд станцаас Дэчинравжайлин хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн зураг төсөл, барилга угсралтын ажил (БЗД, 13, 14, 26 дугаар хороо)	2022	2023	3,787.9	1,000.0
7	Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ татах ажлын зураг төсөл, барилга угсралтын ажил	2022	2023	2,442.7	727.1
8	Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо гэр хорооллын дахин төлөвлөлтийн Б2 хэсэгчилсэн талбайн нэгдүгээр ээлжийн	2022	2023	1,244.2	1,000.0

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
	барилгажилтын төслийн инженерийн шугам сүлжээ				
	ДҮН			21,826.6	7,327.1